

  
МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 4/994

Мандалговь

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын хөнгөн атлетикийн Ахмадын холбоотой хамтран Олон Улсын хэмжээний мастер, Цагдаагийн хурандаа Ц.Найдангийн нэрэмжит Хөнгөн атлетикийн Ахмад мастеруудын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Н.Эрдэнэ-Очир (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)  
А.Отгонбаатар (Биеийн тамир, спортын газрын дарга)  
Ц.Уранбямба (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

М.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

С.Цолмон (Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Дашбилэг (Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн)

2. Олон Улсын хэмжээний мастер, Цагдаагийн хурандаа Ц.Найдангийн нэрэмжит Хөнгөн атлетикийн Ахмад мастеруудын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, 2023 оны 06 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд орон нутагт зохион байгуулахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4823100775